

Эдийн засгийн олимпиад 2024

Бодлого 3

5 сар

Бодлого 3: (Филлипсийн муруй) Олон эмпирик судалгааны үр дүн нь ажилгүйдэл болон инфляцийн түвшин өөр хоорондоо урвуу хамааралтай, өгөө-аваатай (trade-off) харилцаа үүсгэдэг болохыг харуулдаг билээ. Манай улсын ажилгүйдлийн түвшний тоон өгөгдөл дараах байдлаар өгөгдсөн гэж төсөөлье.

Цаг хугацаа (жилээр)	Ажилгүйдлийн түвшин u_t (%)	Ажилгүйдлийн хэвийн түвшин u_t^n (%)	Мөчлөгийн ажилгүйдэл ($u_t - u_t^n$)
2020	10.5	8	a
2021	10	7	b
2022	9.5	7	c
2023	8	6.5	d

Дараах хоёр зүйл өгөгдсөн гэж үзье;

- 2020-2023 онуудын хооронд манай улсын инфляцийн түвшин нийт 5%-иар буурсан;
- Окуны хууль (Okun's law): Манай улсын хувьд мөчлөгийн 1%-ийн ажилгүйдлийн түвшний зардал нь ДНБ-ний 3%-тай тэнцүү байдаг;

Тэгвэл 2020-2023 онуудын хооронд инфляцийн түвшинг 1-иар буулгахын тулд ДНБ-ний хэдэн хувийг зарцуулах (зардал) шаардлагатай вэ?

Бодолт:

- Мөчлөгийн ажилгүйдлийг тооцвол:
- 2020: $a = 10.5 - 8 = 2.5\%$
- 2021: $b = 10 - 7 = 3\%$
- 2022: $c = 9.5 - 7 = 2.5\%$
- 2023: $d = 8 - 6.5 = 1.5\%$
- \Rightarrow нийт мөчлөгийн ажилгүйдлийн хэмжээ:
 $a + b + c + d = 9.5\%$
- Иймд нийт мөчлөгийн ажилгүйдлийн зардлыг ДНБ-иар илэрхийлвэл: $9.5 \cdot 3 = 28.5\%$
- 2020-2023 онуудын хооронд инфляцийн түвшин нийт 5%-иар буурсан тул 1%-ийн бууралтад ДНБ-ний харгазах хэсэг нь:

$$\frac{28.5}{5} = 5.7 \%$$